ULAANBAATAR

Турк хэлний бэлтгэлийн виз мэдүүлэхэд бүрдүүлэх шаардлагатай бичиг баримтууд

1 **Гадаад паспорт болон хуулбар** *(Паспортын хүчинтэй хугацаа 6 сараас доошгүй байх)*
2 **Цээж зураг** *(Сүүлийн 6 сарын хугацаанд авахуулсан, арын фон нь цагаан өнгө бүхий 5х6 хэмжээтэй)*
3 **Визний анкет** *(www.visa.gov.tr цахим хуудсаар онлайнаар бөглөн илгээх; хэвлээд гарын үсэг зуран авч ирэх)*
4 **“Турк Улсруу нэвтрэх батлан даалт болон мэдээллийн маягт” (***Доор хавсаргасан тус анкетийг виз мэдүүлэгч өөрийн гараар бөглөн гарын үсгээ зуран авч ирэх)*
5 **Турк эсвэл англи хэлээр зорилгоо тодорхойлон бичсэн захидал**
6 **Турк хэлний сургалтад бүртгүүлсэнээ нотлох бүртгэлийн хуудас** *(Хуудсанд сургалтанд хамрагдах хугацаа болон түвшинг зааж өгсөн байх шаардлагатай)*
7 **Бүрэн дунд боловсролын гэрчилгээ эсвэл диплом** *(хэрэв оюутан бол оюутны тодорхойлолт)*
8 **Онгоцны билетийн захиалгын хуудас**
9 **Зочид буудлын захиалгын хуудас** *(эсвэл урьж буй хүний нотариатаар баталгаажуулсан урилга)*
10 **Цагдаагийн тодорхойлолт**
11 **Сүүлийн 3 сарын дансны хуулга**

12 Түүнчлэн,

• Хөдөлмөр эрхлэгч эсвэл төрийн албан хаагч бол: **Ажлын газрын тодорхойлолт мөн сүүлийн 3 сарын цалингийн мэдээлэл**

• Хувиараа хөдөлмөр эрхлэгч бол: **Үйл ажиллагаа эрхлэгч ААН/иргэний батламж**

•18 нас хүрээгүй бол: **Эцэг эх эсвэл хууль ёсны асран хамгаалагчаас олгосон нотариатаар баталгаажуулсан зорчих зөвшөөрөл**

• Монгол Улсад оршин суудаг гуравдагч улсын иргэн бол: **Оршин суух үнэмлэхний хуулбар**

13 **Визний хураамж** *(бэлнээр авч ирэх)* – 60$

Виз олгогдсон тохиолдолд зорчих хугацаан дахь аяллын даатгал хийлгэж авч ирнэ.

Анхаарах шаардлагатай зүйлс:

• Визний анкетаа том үсгээр бөглөх бөгөөд паспортын мэдээллүүдээ сайтар нягтлан шалгаж зөв оруулах;
• Визний хариу гарах хүртэл онгоцны билетээ худалдаж авахгүй байх;
• Зорчихоор төлөвлөж буй хугацаанаасаа дор хаяж 1 сарын өмнө виз мэдүүлэх;
• Бичиг баримтуудаа дээр дурдсан дарааллын дагуу бэлдэж авч ирэх;
• Монгол хэл дээрх бичиг баримтуудыг заавал баталгаат орчуулгын газраар орчуулуулсан турк орчуулгын хамтаар авч ирэх, хэрэв бичиг баримт англи хэлээр бол орчуулуулах шаардлагагүйг анхаарна уу.

TÜRKİYE CUMHURİYETİ
İÇİŞLERİ BAKANLIĞI

T.C.
İÇİŞLERİ BAKANLIĞI
GÖÇ İDARESİ
BAŞKANLIĞI

ТУРК УЛС РУУ НЭВТРЭХ ЗОРЧИГЧИЙН БАТЛАН ДААЛТ БА МЭДЭЭЛЛИЙН МАЯГТ

ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ	
Нэр	
Овог	
Иргэний харьяалал	
Төрсөн он, сар, өдөр	
Паспортын дугаар	
Визний анкетийн дугаар	
Турк Улсын хилээр нэвтрэх огноо	

- Зөвхөн визний хүчинтэй хугацаанд Турк Улсад оршин суух эрхийг олгодог.
- Виз нь Турк Улс руу нэвтрэх урьдчилсан зөвшөөрөл болно.
- Визний хүчинтэй хугацаа дуусахаас хамгийн багадаа 60 хоногийн хүчинтэй паспорт эсвэл паспорт орлох бусад бичиг баримтгүй зорчигчийг Турк Улсын хилээр нэвтрүүлэхгүй.
- Турк Улсын виз 180 хоног тутамд 90 хоногоос хэтрэхгүй хугацаагаар олгогдоно.
- Хилээр нэвтэрч байгаа гадаадын иргэд дунд Турк Улс руу нэвтрэхийг хориглосон зорчигч байгаа тохиолдолд нэвтрэх журмыг хариуцсан хууль сахиулах албаас иж бүрэн хяналт тавьж ажиллана.
- Хилийн боомтоор хилээр нэвтрэх, дамжин өнгөрөх зорилгоор ирсэн зорчигч хууль тогтоомжид заасан нөхцөлийг хангаагүй тохиолдолд тус зорчигчийг улсын хилээр нэвтрэх, дамжин өнгөрөх болон хүлээн авах боломжгүй зорчигч гэж үзнэ.
- Турк Улсад оршин суух эрхгүй гадаадын иргэнийг албадан гаргах шийдвэр гаргаж байна. (Иймд тус улсад оршин суух хууль тогтоомжтой танилцана уу.)
- Виз нь ажиллах эрх олгодоггүй бөгөөд тус улсад ажиллах хүсэлтэй иргэн өөрийн эсвэл хууль ёсоор оршин суугаа улс дахь Бүгд Найрамдах Турк Улсын Дипломат Төлөөлөгчийн газарт хандан виз мэдүүлэх боломжтой ба холбогдох байгууллага нь ажлын визийг зөвшөөрсөн тохиолдолд виз олгогдоно.
- Аялал жуулчлалын виз нь тус улсад зөвхөн аялал жуулчлалын зорилгоор зорчиход хүчинтэй.
- Турк Улсад визтэй нэвтэрсэн гадаадын иргэдэд аялал жуулчлалын оршин суух зөвшөөрөл (гэр бүлийн болон аялалын маршрут тодорхой болон тогтмол орлоготой зорчигчоос бусад) олгогдохгүй.

Миний бие дээрх мэдээллийг **УНШААД ОЙЛГОСОН**. Миний бие дээр дурдагсан бүх мэдээллийг үнэн зөв мэдүүлсэн тухай **БАТАЛЖ БАЙНА.** Миний бие виз олгогдсон тохиолдолд визийн хүчинтэй хугацаа дуусахаас өмнө Турк Улсаас гарах үүрэгтэйгээ **БАТАЛЖ БАЙНА.**

Овог, нэр
Гарын үсэг